



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 869

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Цагдаагийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм"-ийг хавсралтаар баталсугай.
2. Дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга /дэд комиссар Д.Эрдэнэбаатар/-д үүрэг болгосугай.
3. Дүрмийг алба хаагчдаар судлуулж мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга, дэд дарга, аймаг, нийслэлийн цагдаагийн газар, хэлтэс, харьяа нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.


ДАРГА, ТЭРГҮҮН  
КОМИССАР

Р.ЧИНГИС

ХУУЛБАР ҮНЭН


Хууль тогтоомжийн хэрэгжилт,  
дотоод ажлын хэлтсийн дарга,  
цагдаагийн хурандаа

А.Даваасүрэн



0903652

Цагдаагийн ерөнхий газрын даргын  
2014 оны 12 дугаар сарын 19-ны  
өдрийн 869 дугаар тушаалын  
хавсралт



**ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН  
САХИЛГЫН ДҮРЭМ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**

**Нийтлэг үндэслэл**

**1 дүгээр зүйл. Ерөнхий зүйл**

1.1.Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрмийн зорилго нь цагдаагийн албаны хэвийн үйл ажиллагаа, захирах захирагдах ёс, хүний эрхийг хангах, алба хаагчийн сахилга, хариуцлагыг журамлан зохицуулах замаар тэдний эрх ашиг, цагдаагийн байгууллага, алба хаагчийн нэр хүндийг хамгаалахад оршино.

1.2.Цагдаагийн алба хаагч нь Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт болон байгууллагын дотоод журам, ажил үйлчилгээний стандарт, цагдаагийн алба хаагчийн тангараг, ёс зүйн хэм хэмжээг чанд сахин биелүүлэхийг цагдаагийн алба хаагчийн сахилга гэнэ.

1.3.Цагдаагийн алба хаагчийн сахилга нь энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг сахиж биелүүлснээр илэрхийлэгдэнэ.

1.4.Цагдаагийн алба хаагч өргөсөн тангарагтаа үнэнч байж, түүнийг ёсчлон биелүүлнэ.

1.5.Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм /цаашид "Сахилгын дүрэм" гэнэ/ нь цагдаагийн алба хаагчдад тавигдах нийтлэг шаардлага, зарчим, сахилгын зөрчлийн төрөл, хэлбэрийг тодорхойлж, сахилгын шийтгэл ногдуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.6.Цагдаагийн алба хаагч бүр сахилгын дүрмийг сахин биелүүлэх үүрэгтэй.

1.7.Цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтнууд нь алба хаагчдад буруу үлгэр дуурайлал үзүүлэх, зохисгүй харьцах, сахилга, дэг журмыг бэхжүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ аваагүй нь сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болно.

1.8.Алба хаагч нь үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хуулийн 4-р зүйл, Цагдаагийн албаны тухай хуулийн 4-р зүйлд заасан зарчмыг баримтална.

1.9.Алба хаагч нь ёс зүйн нийтлэг болон цагдаагийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөн бусадтай зүй бус, хүндэтгэлгүй харилцах, хүнд суртал гаргах, хууран мэхлэх, бусдыг дээрэлхэх, өөрийн байр суурийг бусдаас илүүд үзэх, аливаад анхаарал, хайхрамжгүй хариуцлагагүй хандах, хүч хэрэглэх, шунахайрах, ая тал засах, танил тал харах, аминчирхах үзлээс эрс татгалзвал зохино.

1.10.Алба хаагч нь ажлын байранд ажил хэрэгч уур амьсгалыг бүрдүүлж, ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж ажиллана.

1.11.Алба хаагч нь гадаад төрхөөрөө цэвэрч, соёлтой, ажил хэрэгч, иргэдэд таатай сэтгэгдэл төрүүлэхээр байна.

**2 дугаар зүйл.Сахин баримтлах хэм хэмжээ**

2.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний Цагдаагийн үйл ажиллагаанд холбогдох заалт, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1979 онд баталсан Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль,

Интерполоос баталсан дүрэм журам, Монгол Улсын хууль, тогтоомж, Цагдаагийн тангараг, Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм, Цагдаагийн төв байгууллагаас тогтоосон үйл ажиллагааны журам, Цагдаагийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг алба хаагч бүр дагаж мөрдөнө.

2.2. Алба хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавьж удирдлагаар хангах эрх бүхий албан тушаалтны хуульд нийцсэн зөвлөмж, шийдвэрийг дагаж мөрдөнө.

### **3 дугаар зүйл. Сахилгын зөрчил**

3.1. Энэ дүрмээр хориглож, шийтгэл ногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг сахилгын зөрчил гэж үзнэ.

3.2. Алба хаагчийн гаргасан үйлдэл, эс үйлдэхүйг сахилгын зөрчил гэж үзсэн албан тушаалтан энэ тухай тэмдэглэл үйлдэж зөрчил гаргасан байж болох алба хаагчид заавал мэдэгдэж, хариу тайлбарыг авна. Шаардлагатай тохиолдолд албаны шалгалт явуулж сахилгын зөрчил үйлдэгдсэн эсэхийг тогтооно.

3.3. Зөрчил гаргасан нь тогтоогдсон бол зөрчлийн шалтгаан нөхцөлийг заавал судалж тогтоон байгууллагын удирдлагад танилцуулна.

### **4 дүгээр зүйл. Зөрчлийн талаарх өргөдөл, гомдол**

4.1. Алба хаагч сахилгын зөрчил гаргасан тухай өргөдөл, гомдлыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн бол албаны шалгалт явуулна.

4.2. Албаны шалгалтыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан хугацаанд явуулна. Энэ хугацааны дотор Цагдаагийн байгууллагын дарга албаны шалгалт явуулах хугацааг тогтоож болно.

4.3. Өргөдөл, гомдлын мөрөөр ямар арга хэмжээ авч хэрхэн шийдвэрлэсэн талаар өргөдөл, гомдол гаргагчид хариу мэдэгдэнэ.

4.4. Цагдаагийн төв байгууллагын Дотоод хяналт-аюулгүй байдлын алба нь сахилгын зөрчлийн талаархи өргөдөл, гомдол түүний шийдвэрлэлтийн талаар мэдээллийн сан үүсгэж, хөтөлнө.

4.5. Гаргасан өргөдөл, гомдол нь үндэслэлгүй бөгөөд алба хаагчийг илт гүтгэсэн шинжтэй болох нь тогтоогдвол хуулийн дагуу харьяалах эрх бүхий байгууллагад шалгуулахаар шилжүүлнэ.

### **5 дугаар зүйл. Зөрчлийг шалгаж тогтоох**

5.1. Цагдаагийн төв байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлыг Дотоод хяналт-аюулгүй байдлын алба, бусад цагдаагийн байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлыг тухайн байгууллагын даргын томилсон албан тушаалтан хүлээн авч албаны шалгалт явуулна.

5.2. Албаны шалгалт явуулж байгаа албан тушаалтан нь шууд нотлох баримт, үндэслэл бүхий мэдээ, мэдээлэл, бусад баримтад тулгуурлан сахилгын зөрчлийг шалган шийдвэрлэх, гаргасан зөрчилд тохирсон шийтгэл ногдуулах санал гаргах зарчмыг баримтлана.

5.3. Албаны шалгалт явуулсан алба хаагч нь холбогдох хууль тогтоомжийг үндэслэл болгон дараах саналыг гаргана:

5.3.1. сахилгын зөрчил биш бол гомдол гаргагч иргэнд хариу мэдэгдэх;

5.3.2. сахилгын шийтгэл ногдуулах санал гаргах;

5.3.3. гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх.

5.4.Алба хаагчтай байгуулсан хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэхэд тухайн алба хаагчийн сахилгын зөрчил гаргаагүй нь шагнаж урамшуулах үндэслэл болно.

#### **6 дугаар зүйл.Сахилгын шийтгэлийг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдал**

6.1.Сахилгын шийтгэл нь зөрчлийн шинж, учирсан хохирол, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна.

6.2.Сахилгын зөрчлийн улмаас бусдад хохирол учирсан, албаны үйл ажиллагаа удааширч саатсан, албаны нэр хүндэд ноцтой хохирол учирсан бол зөрчлийн хор уршиг, гэм буруугийн шинж байдлыг харгалзан сахилгын шийтгэлийг хүндрүүлж ногдуулна.

6.3.Сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад сахилга, ёс зүйн зөрчил давтан гаргасан нь хүндрүүлэх нөхцөл байдал болно.

6.4.Сахилгын зөрчил гаргасан алба хаагчийн буруугийн хэлбэр, буруугаа ухамсарласан байдал, ажлын эерэг үр дүн, ёс зүйн төлөвшил, байгуулсан гавьяа, шинээр санаачилсан ажил зэргийг үнэлж хөнгөрүүлэх нөхцөл байдалд харгалзан үзэж болно.

6.5.Энэ дүрэмд заасныг зөрчиж, сахилгын зөрчлийн хор уршиг, шинж байдалд илт үл нийцсэн, үндэслэлгүйгээр сахилгын шийтгэлийг хүндрүүлж эсхүл хөнгөрүүлж ногдуулсан албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэнэ.

#### **7 дугаар зүйл.Сахилгын зөрчилд ногдуулах шийтгэл, хугацаа**

7.1.Алба хаагч энэ дүрэмд заасан зөрчил гаргасан нь тогтоогдвол Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасан сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна.

7.2. Алба хаагч нь Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төсвийн тухай хуулийг зөрчсөн бол тухайн хуульд заасан сахилгын шийтгэлийг ногдуулна.

7.3. Сахилгын шийтгэл ногдуулахдаа Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2, 26.4-26.6 дахь хэсэгт заасан журмыг баримтална.

7.4.Сахилгын зөрчлийг илрүүлсэнээс хойш 1 сарын хугацааг тоолохдоо тухайн алба хаагчийн сахилгын зөрчил гаргасныг шийдвэр гаргах эрх бүхий цагдаагийн байгууллагын дарга олж мэдсэн үеэс эхлэн тоолно.

7.5.Албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан тухай шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлоо тухайн шийдвэрийг мэдсэн өдрөөс хойш 1 сарын дотор дээд шатны байгууллага, эсхүл шүүхэд гаргаж болно.

#### **8 дугаар зүйл.Сахилгын шийтгэл ногдуулах эрх бүхий албан тушаалтан**

8.1.Алба хаагч сахилгын зөрчил гаргасан тохиолдолд Цагдаагийн төв байгууллага, харьяа нэгж, нутаг дэвсгэр хариуцсан болон тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргын дэргэдэх зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэх ба шаардлагатай гэж үзвэл эрх бүхий албан тушаалтан нь шууд тушаал гаргаж сахилгын шийтгэл ногдуулж болно.

8.2.Цагдаагийн төв байгууллагын дарга нь Төрийн албаны тухай хуулийн 26.1.1, 26.1.2, 26.1.3-д заасан сахилгын шийтгэлийг ногдуулна.

8.3.Цагдаагийн төв байгууллагын харьяа нэгж, албадын болон нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нь ахлагч бүрэлдэхүүнээс гаргасан сахилгын

зөрчилд Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1, 26.1.2, 26.1.3-д заасан сахилгын шийтгэлийг ногдуулна.

8.4.Тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нь Төрийн албаны тухай хуулийн 26.1.1, 26.1.2-т заасан сахилгын шийтгэл ногдуулна.

8.5.Зөрчил гаргасан цагдаагийн офицер алба хаагчид Төрийн албаны тухай хуулийн 26.1.3-д заасан сахилгын шийтгэлийг зөвхөн цагдаагийн төв байгууллагын дарга ногдуулна.

8.6.Зөвлөлийн хуралдааны шийдвэрийг байгууллагын дарга сахилгын шийтгэл ногдуулах тухай тушаал гаргаж хэрэгжүүлнэ.

#### **9 дүгээр зүйл.Судалгаа тайлан**

9.1.Алба хаагчдаас сахилгын зөрчил гаргуулахгүй байх зорилгоор бүртгэгдэж шийдвэрлэгдсэн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, мэдээллийг харьяа нэгж, байгууллагуудад хүргүүлнэ.

9.2.Цагдаагийн төв байгууллагын дотоод хяналт-аюулгүй байдал хариуцсан алба нь сахилгын зөрчлийн талаар хийсэн судалгаа, шинжилгээний дүнг эрх бүхий байгууллага, олон нийтэд тайлагнана.

#### **10 дугаар зүйл.Баримт үлдээх**

10.1.Сахилгын шийтгэл хүлээсэн цагдаагийн алба хаагчийн хувийн хэрэгт тухайн шийтгэл ногдуулсан талаарх мэдээллийг оруулна.

10.2.Сахилгын зөрчилтэй холбоотой албаны шалгалтын материалыг Цагдаагийн ерөнхий газрын дарга, Архивын ерөнхий газрын дарга нарын хамтарсан 2014 оны 464/А-111 дүгээр тушаалаар баталсан "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн баримт бичгийн нэр төрөл, хадгалах хугацааны жагсаалт"-ын 3.1 дэх хэсгийн 98-д заасан хугацаанд хадгална.

#### **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

##### **Тодорхой төрлийн сахилгын зөрчил, түүнд ногдуулах сахилгын шийтгэл**

##### **11 дүгээр зүйл.Алба хаагч хууль сахиулагчийн үүргээ үл биелүүлэх**

11.1.Албан үүргээ биелүүлэх явцдаа хууль тогтоомжийг чанд сахиж, хүний эрх, эрх чөлөө, албаны нэр төрийг хүндэтгэн, хүнлэг энэрэнгүй харьцах үүргээ биелүүлээгүй бол уучлал хүсэхийг даалгаж, сануулах шийтгэл ногдуулна.

11.2.Албан үүргээ гүйцэтгэх явцдаа өөрийгөө хэн болохыг танилцуулан мэндчилж, үйлчилгээний стандартын дагуу харьцаагүй бол сануулах шийтгэл ногдуулна.

11.3.Албан үүргээ гүйцэтгэх явцдаа хуулиар тогтоосон мөрдөн шалгах нууц ажиллагааны журам зөрчсөн бол сануулах, уг үйлдлийн улмаас хор уршиг учирсан бол албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах эсхүл тухайн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.

11.4.Албан үүргээ гүйцэтгэхэд бусад хүн, албан тушаалтнаас нөлөөлсөн дарамт шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар дээд шатны удирдлагадаа мэдэгдээгүй үйлдэлд сануулах шийтгэл ногдуулна. Бусдын эрхшээл дарамт нь алба хаагчийг бие махбод, сэтгэл зүйн хувьд гарцаагүй байдалд оруулсан болох нь тогтоогдвол шийтгэл ногдуулахгүй байж болно. Дарамт шахалтад орсон алба хаагчид удирдах албан тушаалтан, хамт олон нь сэтгэл зүйн дэмжлэг үзүүлж, шаардлагатай бол ажлын цагаар амрах боломжоор хангана.

11.5.Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль тогтоомжид заасан үүргийг гүйцэтгээгүй бол зөрчлийн байдлаас шалтгаалж сануулах, албан тушаалын цалингийн

хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл тухайн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.

11.6.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд зааснаар цагдаагийн байгууллагад даалгасан үүргийг биелүүлээгүй бол сануулах эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл ногдуулна.

11.7.Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр жагсаал, цуглааныг албадан тараах ажиллагааг гүйцэтгэх талаар тогтоосон журам зөрчсөн бол зөрчлийн байдлаас шалтгаалж сануулах эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл ногдуулна.

11.8.Алба хаагчдыг олон улсын энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах ажлыг зохион байгуулах үүргээ биелүүлээгүй, хуулиар тогтоосон журам зөрчсөн бол сануулах эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл ногдуулна.

11.9.Иргэн, хуулийн этгээд галт зэвсэг өмчлөх, ашиглах, галт зэвсэг, сум үйлдвэрлэх, захиалах, худалдах, тээвэрлэх, эзэмших журмын биелэлтэд хяналт тавих үүргээ биелүүлээгүй бол сануулах, уг үйлдлийн улмаас хор уршиг учирсан бол албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах эсхүл тухайн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.

11.10.Гэрээт харуулын болон хувийн хамгаалалтын үйл ажиллагаа явуулах журмын биелэлтэд хяналт тавих үүргээ биелүүлээгүй бол сануулах эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл ногдуулна.

11.11.Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээн авч бүртгэх, хойшлуулшгүй арга хэмжээ авах, таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх, гэмт хэргийг илрүүлэх үүргээ биелүүлээгүй бол сануулах, уг үйлдлийн улмаас албаны нэр хүнд, иргэний эрх зөрчигдсөн бол албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах эсхүл тухайн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.

11.12.Хуулиар харьяалуулсан гэмт хэрэг, зөрчлийг шалгаж шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн бол сануулах эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл ногдуулна.

11.13.Хуулиар харьяалуулсан хэрэг зөрчлийг шалгаж шийдвэрлэх ажиллагааны явцад мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих, заавар, зөвлөмжийг өгөх, биелэлтийг тооцох үүргээ зохих ёсоор биелүүлээгүй албан тушаалтанд сануулах эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл ногдуулна.

11.14.Алба хаагч ажил тасалсан бол сануулах, уг үйлдлийн улмаас бусдад хохирол учирсан, албаны үйл ажиллагаа удааширч саатсан, албаны нэр хүндэд ноцтой хохирол учирсан бол албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах эсхүл тухайн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.

11.15.Цагдаагийн төв байгууллагаас тогтоосон үйл ажиллагааны журмыг зөрчсөн бол сануулах, уг үйлдлийн улмаас бусдад хохирол учирсан, албаны үйл ажиллагаа удааширч саатсан, албаны нэр хүндэд ноцтой хохирол учирсан бол албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах

эсхүл тухайн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.

11.16.Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан зөрчсөн бол журмыг зөрчсөн бол сануулах, уг үйлдлийн улмаас бусдад хохирол учирсан, албаны үйл ажиллагаа удааширч саатсан, албаны нэр хүндэд ноцтой хохирол учирсан бол албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах эсхүл тухайн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.

## **12 дугаар зүйл.Алба хаагчийн ёс зүйг зөрчих**

12.1.Албан үүргээ гүйцэтгэхдээ хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, бэлгийн чиг хандлагаар нь ялгаварлан гадуурхаж харьцсан бол уучлал хүсэхийг даалгаж сануулах, уг үйлдлийн улмаас хор уршиг учирсан бол албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах эсхүл тухайн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.

12.2.Албан үүргээ гүйцэтгэхдээ хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдсан, албан тушаал, албаны нэрээр бусдыг эрхшээлдээ оруулах, дарамтлах үйлдэл гаргасан бол албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах эсхүл тухайн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.

12.3.Албан үүрэг гүйцэтгэхдээ бусдын эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол, нэр төрд хохирол учруулж болзошгүй мэдээ, мэдээллийг олон нийтэд болон бусдад мэдээлж зүй бус үйлдэл гаргасан бол уучлал хүсэхийг даалгаж сануулах, уг үйлдлийн улмаас хор уршиг учирсан бол албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах эсхүл тухайн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.

12.4.Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэд үйлчлүүлэгч, хамтран ажиллагсадтайгаа адил тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцах, тэдний нэр төр, алдар хүнд, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгээгүй бол сануулах, уг үйлдлээ давтан гаргасан бол албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах эсхүл тухайн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.

12.5.Удирдах албан тушаалтан алба хаагчидтай бүдүүлэг, зохисгүй харьцсан, хууль бус үүрэг даалгавар өгсөн, өөрт ашигтай шийдвэр гаргуулахаар дарамт шахалт үзүүлсэн бол албан тушаалын албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах эсхүл тухайн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.

12.6.Гэмт хэрэг, зөрчлийг шалгах цагдаагийн байгууллага, нэгжийн харьяалал, чиг үүргийг зөрчсөн бол хувийн ашиг сонирхлоор хандсан эсэхийг тогтоож сануулах, уг үйлдлийн улмаас хор уршиг учирсан бол албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах эсхүл тухайн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.

12.7.Албаны бус зорилгоор байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, мэдээллийн сан, албаны мэдээллийг ашигласан бол сануулах, уг үйлдлийн улмаас хор уршиг учирсан бол албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах эсхүл тухайн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.

12.8.Бусдыг хууль бус үйлдэл, эс үйлдэхүй хийхийг уриалах, чиглүүлэх, шууд ба шууд бус хэлбэрээр өдөөн хатгасан алба хаагчийг хамт олных нь өмнө уучлал хүсэхийг даалгаж сануулах, уг үйлдлийн улмаас хор уршиг учирсан бол албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах эсхүл тухайн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.

12.9.Албан үүргээ гүйцэтгэх явцдаа, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед, ажлын байранд, дүрэмт хувцас өмссөн үедээ согтууруулах ундаа хэрэглэсэн алба хаагчид сануулах эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл ногдуулна. Уг зөрчлийг давтан гаргасан, хор уршиг учруулсан бол тухайн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.

12.10.Алба хаагч нь ажлын болон ажлын бус цагаар согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон бол тухайн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.

12.11.Төр, байгууллага, хувь хүний нууцыг хуульд заасан үндэслэл, журмаас гадуур бусдад задруулах, удирдах албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр албан ажлын мэдээллийг нийтэд болон бусдад мэдээлсэн алба хаагчид сануулах, зөрчлийн шинж байдлаас шалтгаалан албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах эсхүл тухайн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.

12.12.Алба хаагч нь ёс зүйн нийтлэг болон цагдаагийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд бусадтай зүй бус, хүндэтгэлгүй харилцах, хүнд суртал гаргах, хууран мэхлэх, бусдыг дээрлэх, өөрийн байр суурийг бусдаас илүүд үзэх, аливаа асуудалд хариуцлагагүй хандсан бол сануулах, уг үйлдлийн улмаас хор уршиг учирсан бол албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах эсхүл тухайн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.

### **13 дугаар зүйл.Цагдаагийн албаны хууль зөрчих**

13.1.Цагдаагийн байгууллагын тамга тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудсыг зориулалтын бусаар ашигласан бол сануулах, уг үйлдлийн улмаас хор уршиг учирсан бол албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах эсхүл тухайн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.

13.2.Гэмт хэрэг, зөрчил, тэдгээрт шийтгүүлсэн этгээдийн нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, лавлагаа гаргах журам зөрчсөн бол сануулах эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл ногдуулна.

13.3.Олон улсын цагдаагийн байгууллага (интерпол)-ын өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, гадаад орны цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, тэдгээрээс хүлээн авсан мэдээ, мэдээллээр цагдаагийн нийт байгууллагыг хангах үүргээ биелүүлээгүй бол сануулах эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл ногдуулна.

13.4.Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нь үйл ажиллагааныхаа тайланг аймаг, нийслэлийн иргэд оршин суугчдад, түүнчлэн тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, алба хаагч нь үйл ажиллагааныхаа тайланг тухайн нутаг дэвсгэрийн иргэдэд тавиагүй бол сануулах эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл ногдуулна.

13.5.Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын удирдлага нь Цагдаагийн төв байгууллага болон харьяалах Иргэний зөвлөлд ажлаа тайлагнах үүргээ биелүүлээгүй



бол сануулах эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл ногдуулна.

13.6. Удирдах албан тушаалтны хууль ёсны шийдвэр, үүрэг даалгавар, тушаалыг биелүүлэхээс татгалзсан бол шалтгааныг тогтоож, сануулах шийтгэл ногдуулна. Хэрвээ энэ зөрчлийн улмаас байгууллагын үйл ажиллагаа тасалдаж хор уршиг учирсан бол албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах эсхүл тухайн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.

13.7. Нутгийн захиргааны болон төрийн бус байгууллагаас зохион явуулж байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах үүрэгтэй албан тушаалтан энэ үүргээ биелүүлээгүй бол сануулах эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл ногдуулна.

13.8. Дипломат төлөөлөгчийн газар, улсын онц чухал болон бусад объектийг хамгаалах, зарим объектийг түр хугацаагаар хамгаалах, зорчигч, ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх үед үүргээ хангалтгүй биелүүлсэн бол сануулах эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл ногдуулна.

13.9. Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, хүн малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн бусад аюул тохиолдсон үед хорио цээрийн дэглэмийг сахиулах үүргээ биелүүлээгүй бол сануулах эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл ногдуулна.

13.10. Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан үед дэг журам сахиулах үүргээ биелүүлээгүй бол албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.

13.11. Эрх бүхий байгууллага, албан тушаалтны даалгаснаар сураггүй алга болсон хүн, эд зүйлсийг эрэн сурвалжлаагүй бол сануулах эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл ногдуулна.

13.12. Алба хаагчдын өдөр тутмын ажилд хяналт тавьж, хууль тогтоомж, цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүй, хүний эрх, эрх чөлөөг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авах үүрэгтэй албан тушаалтан энэ үүргээ биелүүлээгүй бол сануулах эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл ногдуулна.

13.13. Алба хаагч үүрэг гүйцэтгэх үед хэрэглүүлэхээр тавьж олгосон гав, бороохой, цахилгаан гүйдлээр цохигч, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, холбооны хэрэгсэл, агсамж ашиглах журмыг зөрчсөн бол сануулах, уг үйлдлийг давтан гаргасан, хор уршиг учирсан бол албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах эсхүл тухайн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.

13.14. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам зөрчсөн, мэдээллийн аюулгүй байдлыг алдагдуулсан, албаны мэдээллийг задруулсан бол сануулах эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл ногдуулна.

13.15. Байгууллагын үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй явуулах шаардлагыг хангах төсвийн төслийг үндэслэлтэй боловсруулах, санал гаргах ажлыг зохих журмын дагуу гүйцэтгээгүй бол сануулах, уг зөрчлийг давтан гаргасан, байгууллагад хор уршиг учруулсан бол албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл

хувиар бууруулах эсхүл тухайн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.

13.16.Албан тушаалын цол, түүнийг таних тэмдгийг хууль бусаар хэрэглэсэн, албаны нэрийг хувийн ашиг сонирхолоор ашигласан бол сануулах эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл ногдуулна.

13.17.Албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан алба хаагчийг хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас алба хаагч, түүний гэр бүлийн гишүүнийг цагдаагийн байгууллагаар хамгаалуулах эрхийг нь хангаагүй албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл ногдуулна.

13.18.Хуульд нийцсэн дээд шатны байгууллага, албан тушаалтны үүрэг даалгавар, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах талаар ажлын байрны тодорхойлолтод заасан үүргээ биелүүлээгүй бол сануулах, албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл ногдуулна.

13.19.Алба хаагчаар хуульд зааснаас өөр ажил, үүрэг гүйцэтгүүлсэн бол сануулах эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.

---oO---